



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.04 № 1389
танай _____-ны № _____-т

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Э.АНХБАЯР
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Энхтайвангийн Анхбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Энхтайвангийн Анхбаярын Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн


мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Энхтайвангийн Анхбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: ...1 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЭНХТАЙВАН ОВОГТОЙ АНХБАЯРИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Зорилго

Баянгол дүүргийн хөгжлийн үзэл баримтлалыг шинээр тодорхойлж, эрүүл, аюулгүй, амьдралын таатай орчин бүрдүүлсэн, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоонд тулгуурласан сайн засаглал бүхий орчин үеийн "ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ, ЦАХИМ ЗАСАГЛАЛТАЙ ХОТ" болгон хөгжүүлнэ.

Хоёр. Зорилт

1. Иргэд, оршин суугчдадаа үйлчилдэг, тэднийг дэмждэг, хамтран ажилладаг, хүнд сурталгүй ДҮҮРЭГ.
2. Иргэд, оршин суугчид нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, амрах, зугаалах, тоглох, явган алхах, дугуй унах, ажил, хөдөлмөр эрхлэх таатай орчныг бүрдүүлсэн ДҮҮРЭГ.
3. Иргэд оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах шаардлагад нийцсэн төсвийн шударга хуваарилалт, зарцуулалтын бодлоготой ДҮҮРЭГ.

Гурав. Арга хэмжээ

1. Дүүргийг хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлсэн, өрсөлдөх чадвартай, бие даан хөгжиж, өөрөө өөрийгөө тэтгэх боломжтой болгох эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, нийслэлийн бүх нөөц, бололцоо, төр, захиргааны байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг энэхүү зорилтыг хангахад чиглүүлнэ.
2. Хот байгуулалт, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрийг ханган хөгжлийн тогтвортой орчин бүрдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сайн засаглалыг хөгжүүлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулна.
3. Дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөх, нийслэлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа олон нийтийн санал, оролцоонд тулгуурлан ил тод байх, оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэх зарчмыг мөрдөж ажиллана. Энэ нь нийслэлийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулан хариуцлагатай болгох, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хот байгуулалт, барилга байгууламж барих ажлыг хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулахад чухал ач холбогдолтой болно.
4. Дүүрэг, хороог эдийн засаг, нийгмийн цогцолбор, засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, сум, багтай адилтган шийдвэр гаргаж ирсэн практикийг өөрчилж, нийслэлийн удирдлагыг бэхжүүлэх ажлыг манлайлан идэвхи санаачилга гаргаж ажиллана.
5. Дүүргийн удирдлагыг улирал бүр иргэд, олон нийтэд цахимаар ажлаа тайлагнадаг болгоно. Ингэснээр иргэд нийслэлийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцах боломж нэмэгдэж, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангагдана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР ГАРГАСАН:  Э.АНХБАЯР.

